



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 88


Даланзадгад сум

“Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2. “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Эрүүл мэндийн салбар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

462210205

2





“Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөр (2021-2024 он)

Нэг. Нийтлэг үндэслэл

Засгийн газраас сүүлийн 20 жилийн хугацаанд “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрвөн хөтөлбөр (1997-2016), “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги” (2001-2004, 2005-2010), “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж стратеги” (2009-2013), “Эх, нярайн эрүүл мэнд стратеги” (2011-2015), “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги” (2014-2020), “Нярайн тандалт, шинжилгээний хөтөлбөр” (2014-2020), “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” (2017-2021) зэрэг 10 гаруй бодлогын баримт бичгийг хэрэгжүүлсэн.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын бичиг баримт бичигт нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Тус үзэл баримтлалд улсын хэмжээнд:

II үе шат (2021-2025): Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 30,6 промель байгааг 20, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 2014 онд 15,1 байгааг 11 болгож бууруулахаар зорилтыг тусгасан.

Өмнөговь аймгийн 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрт Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж эх, хүүхдийн эндэгдэл, үр хөндөлтийг бууруулах зорилгоор “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөр хэрэгжүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2/4 тогтоолоор батлагдсан.

Аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөр (2018-2021) 100,000 амьд төрөлтөнд ногдох эхийн эндэгдлийг нэн ялангуяа урьдчилан сэргийлэх боломжтой эхийн эндэгдлийг тэглэх, Өсвөр насны охидын төрөлтийн түвшинг 1,000 охидод 20 хүргэж бууруулснаар 2030 онд нөхөн үржихүйн идэвхтэй насанд хүрэхэд охид эрүүл байх, 10,000 хүн амд ногдох осол гэмтлийн түвшинг улсын дунджаас бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Өмнөговь аймаг 2016-2020 онд үе шаттайгаар “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд сүүлийн 3 жилд эхийн эндэгдэл гаргаагүй, жирэмсний эрт хяналтын хувь 2015 онд 83.2 хувь байсныг 2020 онд 90.2 хувь болгон нэмэгдүүлж, 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшинг 19.1 промель байсныг 11.9 болгон бууруулж, ахиц гаргасан хэдий ч нөхөн үржихүйн эрүүл мэндийн хүртээмж муу, эхийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал байсаар байгаа бөгөөд хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдэл улс, аймгийн дунджаас өндөр байгаа нь тулгамдсан асуудал хэвээр байсаар байна.

Аймгийн эх, хүүхдийн эрүүл мэнд, төрөлт үр хөндөлтийг улс, аймгийн түвшинд харьцуулбал;

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	Улсын түвшин
1.	Нийт төрөлт	1552	1646	1680	
2.	Эхийн ноцтой тохиолдол тоогоор	3	3	2	
3.	Аймгийн төвд төрсөн эхчүүд (хувь)	73,5	67,8	65,6	
4.	Охидын төрөлт 20 түүнээс доош (хувиар)	6,3	5,5	6,3	
5.	Нийт кесевр хагалгаагаар төрсөн(хувиар)	19.0	21.0	21,6	
6.	Амгүй төрөлт	0,6	2.4	0,5	5.2
7.	Дутуу төрөлт (бодит тоо, түвшин)	97/ 6,3	131/7,9	86/5,1	
8.	2500 жингээс бага (бодит тоо, түвшин)	73/4,7	69/4,1	75/4,4	4.4

9.	6 түүнээс дээш удаа хяналт (хувиар)	90,8	93,7	92,6	84.1
10.	Үр хөндөлт бодит тоогоор	815	713	724	
11.	19 наснаас доош үр хөндөлт бодит тоогоор	43	39	52	815

Хүүхдийн эндэгдэл анхаарал татсан асуудал хэвээр байна.

Нялхас, нярайн болон 5 хүртэлх насны эндэгдлийг улс, аймгийн түвшинг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Улсын дундаж
1.	Амьд төрөлт	1409	1301	1552	1646	1680	
2.	Нялхсын эндэгдэл бодит тоо	27	21	23	35	20	
	Түвшин (1000 амьд төрсөн хүүхдэд)	19,2	16,1	14,8	21,3	11,9	11.5
3.	Нярайн эндэгдэл бодит тоо	19	14	20	28	16	
Үүнээс	Түвшин (1000 амьд төрсөн хүүхдэд)	13.5	10.8	12.9	17	9.5	7.8
	Нярайн эрт үеийн эндэгдэл бодит тоо	14	8	18	26	11	
	Түвшин	9.9	6.1	11.6	15.8	6.5	5.8
	Хожуу нярайн эндэгдэл	5	6	2	2	5	
	Түвшин (1000 амьд төрсөн хүүхдэд)	3.5	4.6	1.3	1.2	3	2.1
4.	5 хүртэлх нас хүүхдийн эндэгдэл	34	26	25	41	24	1065
	Түвшин (1000 амьд төрсөн хүүхдэд)	24.1	20	16.1	24.9	14.3	14
5.	Осол гэмтлээс шалтгаалсан /хувиар/			8,6	8,5	8,3	
6.	Перинаталь эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	13.4	14.5	12.2	18.2	14.3	10.6

2020 онд Өмнөговь, Ховд, Хөвсгөл, Баян-Өлгий аймаг 5 хүртэлх насны эндэгдэл урд оноос буурсан үзүүлэлттэй боловч 2016-2020 онуудаас харахад 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин улсын түвшинээс өндөр, үүнээс 83,6 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 76,6 хувийг нярайн эндэгдэл, нярайн эндэгдлийн 76,5 хувийг нярайн эрт үеийн эндэгдэл эзэлж байна.

Жирэмсний хяналтын чанар хангалтгүй байна. Жирэмсний эрт хяналт 90 хувь түүнээс дээш байгаа ч перинаталь эндэгдэл өндөр байсаар байна. Мөн иргэдийн шилжилт хөдөлгөөн их, түр оршин суугчдын эмчийн хяналтад ороогүй төрөх, эмнэлгийн тусламж оройтож авах тохиолдол гарч байна.

Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ хүртээмжгүй байна. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр болон бусад судалгаагаар гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээ, үр хөндөлт, түүний дотор давтан үр хөндөлт ялангуяа өсвөр үеийнхэн, залуучуудын дунд нэмэгдсээр байна. Аймгийн төрөх насны үр хөндөлтөөс сүүлийн 3 жилийн дунджаар анх удаа үр хөндөлтөд 76,6 хувь, улмаар өсвөр үеийнхэн, залуучуудын дунд үр хөндөлт нэмэгдсээр байна.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн хэрэглээ буурч 2018 онд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 53,7 хувь, 2020 онд 50,7 хувь нь жирэмслэхээс сэргийлэх ямар нэгэн эм, хэрэгсэл хэрэглэдэг болж буурсан байна.

Өсвөр үе, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол хангалтгүй байна. Нийт төрөлтийн охидын төрөлт 2018 онд 6,3%, 2019 онд 5,5%, 2020 оны байдлаар 6,3% болж өссөн байна. Хүн ам, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, хандлага, дадалд тогтвортой өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна. Залуучуудад янз бүрийн сэдвээр сургалт, сурталчилгаанд хамруулдаг боловч үр дүн нь хангалтгүй байна.

ХДХВ/ДОХ-ын талаар цогц мэдлэгтэй залуучуудын эзлэх хувь эрэгтэйчүүдийн дунд ердөө 20.7 хувь, эмэгтэйчүүдийн дунд 22.8 хувь байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2016 оны тоо мэдээгээр 5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн шалтгаант нас баралт нийт нас баралтын 14.4 хувийг эзэлж байгаа бөгөөд түүний 76.5 хувь нь түлэгдэлтийн улмаас нас барсан байна. Түлэгдсэн шалтгаанаар нас барсан хүүхдүүдийн 77 хувь нь халуун хоол цайнд, 23 хувь нь халуун усанд түлэгдсэн байгаагаас үзэхэд эцэг, эх, асран хамгаалагчаас хүүхдэд тавих анхаарал, халамж хангалтгүй байгааг харуулж байна.

Өмнөговь аймгийн хувьд уул уурхайн салбарыг дагаж, суурин болон хөдөлгөөнт хүн амын тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа ч эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт, орон тоо, хүчин чадал нь тэр хэмжээнд хүрч нэмэгдэж чаддаггүй тул хэнийг ч орхигдуулахгүй тусламж үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлүүд гарч байна.

2019, 2020 онд ихэнх нутгаар бороо хур муу, ихэнх нутгаар ган зудтай улмаар отор нүүдэлд олон айлууд аймаг дотроо болон ойролцоо нутгаар нутаглаж эмнэлгийн тусламж авахад бэрхшээлтэй, хяналтад буй жирэмсэн, төрөх насны эмэгтэй, нярай, хүүхдүүд хяналтаас хоцрох зэрэг олон асуудлууд гарч байна.

2019 оны 02 сараас Дэлхий нийтэд цар тахал Коронавируст халдвар (КОВИД-19) өвчний улмаас Монгол улсын хэмжээнд хэсэгчлэн болон бүрэн хол хорио тогтоосноор эх хүүхэд сум, өрхийн эмнэлэгт хяналтад байх, тусламж авах, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг цаг алдахгүй очих боломжууд хязгаарлагдаж эрсдэлд орох, гэрээр үйлчилгээ үзүүлэхэд шатахуун, унаа, хүний нөөцийн дутагдалд орох өндөр эрсдэлтэй байна.

Өмнөговь аймгийн эх, хүүхдийн эрүүл мэндийн статистик үзүүлэлт, тулгамдсан асуудлын хүрээнд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын 2020-2024 оны "Нутгийн хишиг" хөтөлбөрийн салбарын зорилтод нийцүүлэн шинэчлэн боловсруулж, 2021-2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа,  
санхүүжилт:

#### 2.1. Хөтөлбөрийн зорилго:

Эх, хүүхэд, охид, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад нийгэм эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн, эцэг эх, иргэд, иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай, ээлтэй тусламж үйлчилгээг тэгш хүргэснээр сэргийлж болох эрсдэлт хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тогтвортой бууруулна.

#### 2.2. Хөтөлбөрийн зорилт:

Зорилт 1. Эмэгтэйчүүд, охид, залуучууд, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад хувь хүн, гэр бүл, байгууллага, хамт олны оролцоог нэмэгдүүлэн, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйлийг төлөвшүүлнэ.

Зорилт 2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламжийг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, тусламж үйлчилгээний хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.

Зорилт 3. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд ур чадвар бүхий хүний нөөцийг бэхжүүлэн, анагаах ухааны дэвшилтэт технологид тулгуурлан тусламж үйлчилгээний ээлтэй орчинг бүрдүүлнэ.

#### 2.3. Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт:

##### 2.3.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

##### 2.3.2. Санхүүжилт:

а/ Орон нутгийн төсөв

б/ Улсын төсөв

в/ Төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив,

г/ Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хандив, тусламж

д/ Бусад санхүүгийн эх үүсвэртэй байна.

### Гурав. Үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

3.1. “Эмэгтэйчүүд, охид, залуучууд, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад хувь хүн, гэр бүл, байгууллага, хамт олны оролцоог нэмэгдүүлэн, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйлийг төлөвшүүлнэ” зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.1.1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн зөв дадал, хандлагыг төлөвшүүлэх, жирэмсний үеийн хооллолт, чийрэгжүүлэлт, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг олон хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах:

3.1.2. Шийдвэр гаргагчид болон байгууллага, аж ахуйн нэгжид ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан дэмжлэгт орчныг бүрдүүлэх:

3.1.3. Охид, эмэгтэйчүүдэд хүсээгүй жирэмслэлт болон үр хөндөлтийн хор уршиг, гэр бүл төлөвлөлтийг ач холбогдлыг ойлгуулах мэдээлэл, сургалт, сурталчилгааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах:

3.1.4. Эцэг, эхчүүдэд хүүхдийн асаргаа сувилгааны багц сургалтыг чанартай хүртээмжтэй хүргэх, мэдлэг хандлагыг дээшлүүлэх:

3.1.5. Өсвөр үеийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт нөхөн үржихүйн боловсрол олгох сургалтыг чанаржуулах, гэр бүл төлөвлөлт, бэлгийн боловсрол олгох сургалтыг өсвөр үеийн кабинетын үйлчилгээг өргөжүүлэх замаар тасралтгүй олгох, үйл ажиллагааг тогтмолжуулах:

3.1.6. Хүүхдийн ахуйн болон зам тээврийн ослыг бууруулахад байгууллага, олон нийтийн оролцоотойгоор сургалт, сурталчилгаа, зөв дадлыг эзэмшүүлэх:

Хүрэх үр дүн: Нөхөн үржихүйн болон хүүхдийн эрүүл мэндийн асуудлаар хувь хүн, гэр бүлийн гишүүд, олон нийт, шийдвэр гаргагчдын мэдлэг ойлголт нэмэгдэж, тэдгээрийн оролцоо, дэмжлэг сайжирсан байна. Гэр бүл төлөвлөлт, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт буурч, эцэг, эхийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.

3.2. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламжийг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, тусламж үйлчилгээний хяналтын тогтолцоог бэхжүүлнэ” зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.2.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд, өсвөр үе, залуучуудын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг тасралтгүй зохион байгуулж, эрүүлжүүлэх, хянах;

3.2.2. Малчид, отор нүүдэл хийж байгаа гэр бүлийн гишүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны хүүхдэд зайн оношлогоо, явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, (хөх, умайн хүзүүний хавдрын гэх мэт) эрт илрүүлэг, шинжилгээг үргэлжлүүлэх;

3.2.3. Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, 6-23 сартай хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл, 5 хүртэлх насны хүүхдийг А, Д амин дэмээр тасралтгүй хангах;

3.2.4. Нярайн төрсний дараах хяналт, асаргаа сувилгааг сайжруулах замаар эндэгдлийг бууруулах, эмнэлэгт 6 түүнээс дээш хоног нарийн мэргэжлийн эмчийн хяналтад байлгах;

3.2.5. Жирэмсний үеийн хяналтыг сайжруулах, жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаагийн хяналтыг хийх, тэмбүү, ХДХВ, элэгний В, С вирусын халдвар илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах:

Хүрэх үр дүн: Нөхөн үржихүйн насны хүн ам, хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөл, нас баралт буурна.

3.3. “Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд ур чадвар бүхий хүний нөөцийг бэхжүүлэн, анагаах ухааны дэвшилтэт технологид тулгуурлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ээлтэй орчин бүрдүүлнэ” зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.3.1. Нарийн мэргэжлийн эмч, сувилагч тусгай мэргэжилтнийг тасралтгүй бэлтгэн, төрөлжсөн мэргэжлээр мэргэшүүлж, ажлын байран дээр дагалдан сургах замаар эмнэл зүйн цогц сургалтыг зохион байгуулах

3.3.2. Тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, онол, практикийн бага хурал, зөвлөгөөн, чуулга уулзалтыг зохион байгуулах

3.3.3. Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээ, ургийн болон нярайн төрөлхийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэх шинэ техник, технологийг нэвтрүүлэх, үндэсний болон олон улсын эмнэлзүйг нэвтрүүлэх

3.3.4. Нөхөн үржихүй, эрчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд үргүйдлийг оношлох эмчлэх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, тоног төхөөрөмжийн хангалт, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх;

Хүрэх үр дүн: Мэргэшсэн, ур чадвар бүхий хүний нөөцийн хангалт, тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, чанар сайжирч, эх, хүүхэд, эрчүүдийн өвчлөл, хүндрэл буурна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, үүрэг:

4.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар /Нийгмийн бодлогын хэлтэс/, ажлын хэсэг:

4.1.1. Аймгийн Засаг даргаар ахлуулсан Эрүүл мэндийн салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газар /Нийгмийн бодлогын хэлтэс/, хөтөлбөрийн ажлын хэсэг хамтран нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажиллах:

4.1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай төсвийг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, батлуулах, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

4.1.3. Хөтөлбөрийн үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнах, мэдээлэх:

4.2. Сумын Засаг даргын Тамгын газар:

4.2.1. Сумын Засаг дарга, түүний Тамгын газар, эрүүл мэндийн салбар зөвлөлөөс төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, хяналт тавих:

4.2.2. Сумын хүн амын шилжилт хөдөлгөөн, түр оршин суугаа иргэдийн бүртгэл судалгааг нарийвчлан бүрэн гарган шаардлагатай тохиолдолд шилжүүлгийг журмын дагуу хийлгэж, шуурхай бүртгүүлдэг болох, гудамж, хорооллыг хаягжуулах

4.2.3. Өндөр өртөмтгий жирэмсэн эхийг II, III дахь шатлалын хяналтад шилжүүлэх, төрсний дараа гэрт нь хүргэхэд жил бүр тодорхой зардал төсөвлөж, эх, нярайн эрүүл мэндийг хамгаалах болон сумын эмнэлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

4.2.4. Иргэдэд эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулахад санхүү, хүний нөөц, боломжийг бүрдүүлэх, сурталчлах, тусламж, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах

4.2.5. Отор нүүдэл, ган зуд, цар тахлын үед эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй хүргэхэд бүх талаар дэмжих

4.3. Эрүүл мэндийн байгууллагууд:

4.3.1. Сум, өрхийн Эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлгийн 0-5 насны хүүхдийн эргэлт, хяналтын байдалд жилд 2 удаа хяналт үнэлгээ хийж, сумын Эрүүл мэндийн салбар зөвлөлд үр дүнг мэдээлж хяналтыг сайжруулах, эндэгдлийг бууруулах арга хэмжээг удирдлага арга зүйгээр ханган ажиллах

4.3.2. Эх, хүүхдийн эндэгдлийн үнэлгээ дүгнэлтийг тухай бүрт хийж, алдаа зөрчлийг илрүүлж засах, сайжруулах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж үр дүнг мэдээлэх, хариуцлага тооцох механизмыг бүрдүүлж ажиллах

4.3.3. Шаардлагатай тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэглээ, бэлэн байдлыг хангаж ажиллах

4.3.4. Өсвөр насны охид, эмэгтэйчүүдэд сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн боловсролыг олгоход бусад хамтрагч байгууллагад удирдлага арга зүйгээр хангах

#### 4.4. Боловсролын байгууллагууд:

4.4.1. Өсвөр насны охид, хөвгүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, ялангуяа НҮЭМ-ийн болон БЗДХ-ын талаар тодорхой мэдлэг олгох, урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшил тогтоох ажлуудыг улирал бүр зохион байгуулж хэвшүүлэх, бусад байгууллагуудтай энэ чиглэлээр үр дүнтэй хамтран ажиллах

4.4.2. Сургуулийн өсвөр насны сурагчдыг эрүүлжүүлэх ажлыг сургууль бүр зохион байгуулж хэвшүүлэх

4.4.3. Сурагчдын эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах

4.4.4. Сургууль, цэцэрлэгийн эмч нарыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалтад хамруулж, мэдлэг, заах арга зүйг дээшлүүлэх:

4.4.5. Бэлгийн эрүүл ахуй, халдварт өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, эцэг эхчүүдтэй хамтран ажиллах

4.4.6. Сургуулиудад эрүүл мэндийн чиглэлээр өсвөр үеийн клубуудыг байгуулах, үе тэнгийн сургагч бэлтгэн хамтран ажиллах

4.4.7. Өсвөрийн кабинетуудын үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй зохион байгуулж, хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлж, өргөжүүлэх

#### 4.5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар:

4.5.1. Хүүхдийн эрхийг хамгаалах, нууцлалыг хадгалах, хөгжлийн шинэ аргаар ажлыг сайжруулах

4.5.2. Хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх олон талт ажлыг зохион байгуулах

4.5.3. Гэр, бүл, хүүхэд, залуучуудад чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулан, мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах

4.5.4. "Эх хүүхдэд ээлтэй" байгууллага, гэр бүл, "Эрүүл мэндийг дэмжигч" хамт олон, аж ахуй нэгж, төрийн байгууллагыг тодруулах, үйл ажиллагааг сурталчлах

4.5.5. Хүүхдийн осол гэмтлийг бууруулах аян, олныг хамруулсан компани ажил, залуу эцэг эхчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, зөв аав, ээж байх бүх талын олон талт ажлуудыг санаачлан зохион байгуулах

#### 4.6. Бусад төрийн болон төрийн бус байгууллагууд:

4.6.1. Эх хүүхдийн эрүүл мэндийн төлөө сайн үйлсэд нэгдэж, жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд ээлтэй орчин бүрдүүлж, цаг тухайд нь жирэмсний хяналтдаа орох, товлосон хугацаандаа үзлэгт хамрагдах боломжийг бүрдүүлж, бүхий л талаар дэмжиж, ажиллах

4.6.2. Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж хэвшүүлэх, хамтран ажиллах

4.6.3. Байгууллагын ажилтнуудаа эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих ажлыг үе шаттай авч хэрэгжүүлэх, тайлагнах

4.6.4. Хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд эрүүл мэндийн нэвтрүүлгийн тогтмол цагтай болж, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сурталчилгаа, мэдээллийг олон нийтэд хүргэх, тайлагнах

4.6.5. Залуу аавуудад эх, хүүхдийг төрсний дараа асран халамжлах боломжийг бүрдүүлэх, 6 ба түүнээс дээш хоног цалинтай чөлөө олгох боломжийг бүрдүүлэх, дотоод журамд оруулах

#### Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт:

5.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, зохицуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Нийгмийн бодлогын хэлтэс/, хөтөлбөрийн ажлын хэсэг зохион байгуулна.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, мэдээллээр хангах, хяналт тавих ажлыг аймгийн Эрүүл мэндийн газар хариуцан гүйцэтгэнэ.

Зургаа. Хяналт шинжилгээ, үр дүн:

6.1. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан ажлын явц, хэрэгжилтийг нэгтгэн, үр дүнг тооцох, тайлагнах ажлыг жил бүрийн 7, 12 дугаар сард багтаан Эрүүл мэндийн газар, Нийгмийн бодлогын хэлтэст хамтран аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хөтөлбөрийн үр дүнг тайлагнана.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үр нөлөөний болон үр дүнгийн дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2020 оны эрүүл мэндийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглана.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020 он			Хүрэх түвшин	
		Өмнөговь	Аймгуудын дундаж	Улсын дундаж	2022 он	2024 он
1.	Эхийн эндэгдлийн тоо	0	52.2	30.2	0	0
2.	Жирэмсний эрт хяналтын хувь	90.2	90.5	89.9	90.5	90.8
3.	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш хамрагдсан хяналтын хувь	92.7	85.1	84.6	94.5	96.0
4.	Өсвөр насны охидын төрөлтийн эзлэх хувь	6.3	25.7	27.6	5.8	5.5
5.	Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	11.9	11.2	11.5	11.2	10.5
6.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	14.3	14.6	14	14	13.5
7.	Перинаталь эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	14.3	9.9	11.1	11	10
8.	Осол гэмтлээс шалтгаалсан, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол	3			2	1
9.	Нөхөн үржихүйн цогц кабинетаар үйлчлүүлсэн эмэгтэйчүүдийн тоо	160	-	-	300	500
10.	Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь	50.7		54.6	55	58
11.	Өсвөр насны охидын кабинетаар үйлчлүүлсэн хувь	230			450	600
12.	Үр хөндөлтийн түвшин /1000 амьд төрөлтөд/	431			410	380
13.	Хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчийн хангалт /10.000 хүн амд/	6.6	-	-	6.8	7